

**ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.11.21.

Орхон аймаг

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Оноо
1	Хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг байгууллагын хэмжээнд тодорхойлох.	Жендерийн тэгш байдлыг хангах, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогын хүрээнд 2024 онд хийх ажлын дэд төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар баталгаажуулан, биелэлтийг ханган ажиллах	Жендерийн тэгш байдлыг хангах, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогын хүрээнд 2024 онд тус хэлтэст хийх ажлын 6 заалт бүхий дэд төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас гаргасан жендерийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж хүйсийн тэгш байдлыг ханган ажиллаж байна.	Жил дээ
2	Байгууллагын хэмжээнд жендерийн ялгаварлан гадуурхал буюу эмэгтэй, эрэгтэйгээр бие биенээ хүйсийн ялгаатай байдлаар үл тоомсорлох, үл хүндэтгэх байдал гаргуулахгүй байх	Байгууллагын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа аливаа урлаг, спортын арга хэмжээнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж адил тэгш оролцуулахад анхаарч ажиллах.	Улсын бүртгэлийн байгууллагын 84 жилийн ойн баярын өдрийг угтаж хэлтсийн бүх албан хаагчдын дунд хүйсийн тэгш байдлыг ханган, холимог баг гаргаж, гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүллээ.	11 сард
3	Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд хүйсээр ялгаварлан гадуурхахгүйгээр ажилтныг сонгон шалгаруулах	Тус хэлтэст төрийн жинхэнэ албанд сул орон тоо гарсан тохиолдолд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс төрийн албаны нөөцөөс судлан авч Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад санал хүргүүлж шийдвэрлүүлэх	Тус хэлтэст төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гарч Байгууллагын дотоод журамд заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын Төрийн албаны салбар зөвлөл, Хүний нөөц сургалтын хэлтэст хүсэлт гаргаж сул орон тоог зарлан, Иргэний улсын бүртгэгчийн түр орон тоон дээр Б.Шинэбаяр томилогдон, мөн Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч	Жил дээ

			Г.Саруул үндсэн орон тоон дээр шилжин томилогдсон. Тус хэлтэст нийт 29 ажилтан албан хаагч ажиллаж байгаагаас 20 эмэгтэй, 9 эрэгтэй ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.	
4	Албан хаагчдад олгох цалин, үнэлгээний асуудалд адил тэгш хандах, тэгш боломж олгох, шагнал урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд жендерийн тэгш байдлыг хангах	Ижил ажлын байранд ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлсийг адил тэгш олгох, шагнаж урамшуулах, сургалтад хамруулах зэрэг үйл ажиллагаанд жендерээр ялгаварлах явдал гаргалгүйгээр ажлын идэвх санаачилга, хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзах	- МУ-ын ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолыг үндэслэж албан хаагчдад адил цалин, хөлс, шагнал урамшуулалд тодорхойлох, илүү цагаар ажилласан хөлс, сонгуулиар ажилласан итгэмжлэгдсэн ажилтны цалин хөлсийг баталсан төсвийн хүрээнд ижил тэгш олгосон.	Жил дээ
5	Албан хаагчдад Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан таниулах, мэдлэг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах	Эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдал эмэгтэйчүүдийг алагчлах явдлыг тодорхойлох талаар цахим сурталчилгааны материал бэлдэн байгууллагын пэйж хуудсаар түгээх	Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэгийн “Жендерийн мэдрэмжтэй жишиг байгууллага” подкастыг пэйж хуудсаараа дамжуулан албан хаагчид болон олон нийтэд түгээлээ. Мөн Доктор профессор М.Толя багшийн “Хүн байхын утга учир” сургалтад байгууллагын бүх албан хаагчийг хамрууллаа.	Жил дээ
6	Албан хаагчдыг ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх санал асуулга авах	Эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдал хангагдсан байна.	11 дүгээр сарын 19-ны өдөр хэлтсийн шуурхай цуглаан нийт албан хаагчаас бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх 5 асуултаар санал асуулга авахад зөрчил дутагдал байхгүй гэсэн байна.	2024. 11сар

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС